



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/792

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цахим Ховд дэд хөтөлбөрийн хүрээнд цахим үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үр ашгийг нэмэгдүүлэхэд шаардагдах ухаалаг самбар 2 /хоёр/ ширхэгийг худалдан авах зардалд 27 080 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 11 900 000 төгрөг /Арван нэгэн сая есөн зуун мянган/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.13 дахь Цахим Ховд хөтөлбөр арга хэмжээний зардлаас, 15 180 000 төгрөг /Арван таван сая нэг зуун наян мянган/-ийг Техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг Даргын орлогч дарга /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 3976
D/Zah-A/792-Bo



Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 16-ны өдрийн
А/792 дугаар захирамжийн хавсралт

АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д. д	Засвар үйлчилгээний зардлын төрөл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/	Ашиглагч
1	Max hub V5 загварын 65 инчийн ухаалаг дэлгэц /i5 8400, DDR4 8GB/128 SSD Core HD Grapics, 2*USB3.0 port, Mic in, windows 10 enterprise version included, 20 touch point, 4K wireless, mouse, keyboard, Maxhub share dongle/	ш	1	11 900 000	11 900.0	Аймгийн Онцгой комисс, шуурхай штаб, бусад цахим хурлын арга хэмжээнд
2	Камер: Maxhub US10	ш	1	2 300 000	2 300.0	
3	Speaker phone: Maxhub speakerphone	ш	1	980 000	980.0	
4	Max hub EDU загварын 75 инчийн ухаалаг дэлгэц /Android 9.0, 4GB RAM 32GB ROM, i5 8400, DDR4 8G/128 SSD Core HD Grapics, windows 10 enterprise version, 20 touch point, 4K wireless, keyboard mouse, Maxhub share dongle /	ш	1	11 900 000	11 900.0	Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
5	Зориулалтын хөл Mobile stand	ш	1	0	0	
ДҮН					27 080.0	

-oOo-